



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/42

Цагаан-Овоо

Малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийн  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.9, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны А/115 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас хорогдсон малын сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

|                       |                                                                         |
|-----------------------|-------------------------------------------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Ганчимэг (Засаг даргын Тамгын газрын дарга)                           |
| Гишүүд                | Х.Адъяасүрэн (1 -р багийн Засаг дарга)                                  |
|                       | Б.Шинэтулга (2-р багийн Засаг дарга)                                    |
|                       | П.Тогосмаа (3-р багийн Засаг дарга)                                     |
|                       | Н.Ганбаяр (Засаг даргын Тамгын газрын жижүүр)                           |
|                       | Ч.Цэнгэлсайхан (Засаг даргын Тамгын газрын жолооч)                      |
|                       | Б.Баттулга (Салхит ХХК мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч) |
|                       | Ш.Ойнбор (Луус ХХК мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч)     |

Нарийн бичгийн дарга: Ц.Бормаам (Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

2.Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж булж устгах, халдваргүйтгэлийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Байгаль цаг агаарын хүндрэлээс болж зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг халдварт өвчин тархах, байгаль орчныг бохирдуулахаас сэргийлж уст цэг, төв авто зам дагуух, төв суурийн газраас цуглуулж, нэгдсэн усгалын "Хөх овооны" цэгт булж устгах, халдваргүйтгэх ажлыг 04 дугаар сарын 04-ны өдрөөс 06 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, дүн мэдээг долоо хоног бүрий 3 дахь өдөр Мал эмнэлгийн газарт мэдээлж ажиллахыг нарийн бичгийн дарга (Ц.Бормаам)-д даалгасугай.

4.Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах, байгаль орчныг цэвэрлэх халдваргүйтгэлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

5.Устгалын ажилд шаардлагатай зардлыг Засаг даргын нөөц, хөрөнгөнөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ганчимэг), нягтлан бодогч (Г.Нямсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ